



## АВТОБУСНЫ БУУДЛЫН ЗАСВАР ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2024 оны 07 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

1	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоол.</li> </ul>
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	<ul style="list-style-type: none"> <li>- Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо Буянт-Ухаа-2 хорооллын баруун хойд талд (Эцсийн буудал)</li> <li>- Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо Шүрт Хотхоны хойд талд (Хоёр талдаа автобусны буудал)</li> </ul>
3	Зориулалт хүчин чадал	<ul style="list-style-type: none"> <li>- Автобусны буудлын тохижилт, завсар шинэчлэл хийх.</li> </ul>
4	Одоогийн байдал	<ul style="list-style-type: none"> <li>- Нийтийн тээврийн зогсоолгүй, тохижилтгүй талбай.</li> </ul>
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none"> <li>- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.</li> </ul>
6	Төслийн захиалагч	<ul style="list-style-type: none"> <li>- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар</li> </ul>
7	Төсөл гүйцэтгэх байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага</li> </ul>
8	Төсөл гүйцэтгэх үе шат	<ul style="list-style-type: none"> <li>- Талбайн судалгаа, хэмжилт хийж, хорооны Засаг даргатай зөвшилцсөний дараа ажлын тоо хэмжээг захиалагчид танилцуулах.</li> <li>- Нийслэлийн Нийтийн тээврийн газартай заавал зөвшөлцөх.</li> <li>- Нийслэлийн замын хөгжлийн газартай зөвшилцөх</li> <li>- Загвар зураг боловсруулж батлуулах.</li> <li>- Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. /магадлал хийгдсэн байх/.</li> <li>- Төсөвт өртөг /магадлал хийгдсэн байх/.</li> </ul>
9	Орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<p><b>Зогсоолын байгууламж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Архитектур орон зайн төлөвлөлтийг тус байршлын онцлог, шаардлага, орц гарц, орчны ерөнхий төлөвлөгөөтэй тохижилтын шийдэл гаргаж автобусны буудал төлөвлөх.</li> </ul> <p><b>Явган зам, талбай:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Зорчигчдын амрах талбай болон хүний хөдөлгөөнийг салгаж зорчигчдын хөдөлгөөнийг сайжруулах орц гарцыг нэмэгдүүлж төлөвлөх.</li> <li>- Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009 стандарт.</li> </ul> <p><b>Бусад</b></p>

		<ul style="list-style-type: none"> <li>- Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих өрөнхий шаардлага UCS1601B:2022 стандартыг мөрдөх.</li> <li>- Шаардлагатай тэмдэг, тэмдэглээг байршуулах</li> <li>- Гадна гэрэлтүүлэг, хогийн сав гэх мэт тохижилтын бусад элементийг төлөвлөх.</li> </ul>
10	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><b>Монгол Улсын хуулиуд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Барилгын тухай хууль</li> <li>- Газрын тухай хууль</li> <li>- Усны тухай хууль</li> <li>- Бусад холбогдох хууль</li> </ul> <p><b>Норм, нормативууд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД30-01-04/</li> <li>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм</li> </ul>
11	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаргуугийн ус зайлзуулах шийдлийг орчны байгууламжуутдай уялдуулан нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх.</li> </ul>
12	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.</li> </ul>
13	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотын "Нэг хот, Нэг стандарт"-ын эмхэтгэл болох UCS стандартуудыг мөрдөж ажиллах.</li> <li>- UCS 1601B Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих өрөнхий шаардлага.</li> </ul>

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  О.МӨНГӨНШАГАЙ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ИНЖЕНЕР  М.БАЯРБЯМБА

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 21 ДҮГЭР ХОРОО ШҮРТ ХОТХОН ЯВАХ ЗАМД



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 21 ДҮГЭР ХОРОО БУЯНТ-УХАА-2 ХОТХОН ХОЙД ТАЛД



БАТЛАВ  
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

С.ЭНХБАЯР

2024 оны 7 дугаар сарын... өдөр

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 12 ДУГААР ХОРООНД ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРОХ БАГА  
СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГУУД РУУ ОРОХ АВТО ЗАМЫН ЗУРГИЙН  
ДААЛГАВАР**

2024 оны 7 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

**Ажлын цар хэмжээ:**

Энэхүү ажил нь иргэдэд аюулгүй, тохилог орчинд амьдрах, ажиллах таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой.

1	Төсөл боловсруулах ундэслэл	- Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоол.
2	Байршил	- Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо.
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	- Хан-Уул дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт.
4	Газрын бартаалаг, төвөгшил	- Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах.
5	Одоогийн байдал	- Сул шороон хөрс бүхий талбай.
6	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
7	Төслийн захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
8	Төсөл гүйцэтгэх байгууллага	- Зураг төсөл боловсруулах байгууллага нь: Зам тээврийн хөгжлийн яамнаас олгодог: 2.8.1.4 Хотын авто зам, замын зураг төсөл боловсруулах эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой.
9	Төсөл гүйцэтгэх үе шат	- ХБХСГ-аас архитектур төлөвлөлтийн даалгавар авах. - Төлөвлөлтийн шатанд талбайн судалгаа, хэмжилтийг илүү дэлгэрэнгүй хийж авто замын план зургийг ХБХСГ, НЗХГ, НГЗБА, ГУББГ ОНӨААТҮГ-тай тус тус зөвшшилцсөний үндсэн дээр нарийвчилсан зураг төсөлд холбогдох газруудаас санал аван зураг төслийг баталгаажуулах. - Загвар зураг боловсруулах (Нүүр хуудас батлагдсан байх). - Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. (магадлал хийгдсэн байх). - Төсөвт өртөг (магадлал хийгдсэн байх).
10	Орон зайн төлөвлөлтэд тавигдах шаардлага	- Архитектур орон зайн төлөвлөлтийг тус байршлын онцлог, шаардлага, орц гарц, орчны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах. <b>Явган зам, талбай:</b> - Зорчигчдын амрах талбай болон хүний хөдөлгөөнийг салгаж зорчигчдын хөдөлгөөнийг сайжруулах орц гарцыг нэмэгдүүлж төлөвлөх. - Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009 стандарт.

		<p><b>Авто зогсоол</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Авто замын явах хэсэг, тээврийн хэрэгслийн зогсоол, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу төлөвлөх.</li> <li>- Авто зогсоолын /БНБД 21-5-10/, автомашины ангиал, ерөнхий шаардлага, Монгол улсын стандарт "MNS:5342:2003"-д нийцүүлж төлөвлөх.</li> </ul> <p><b>Бусад</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гадна гэрэлтүүлгийг орчин үеийн загвартай эрчим хүчинд хэмнэлттэй гэрэлтүүлэг шинээр төлөвлөх.</li> </ul>
11	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><b>Монгол Улсын хуулиуд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Авто замын тухай хууль</li> <li>- Газрын тухай хууль</li> <li>- Усны тухай хууль</li> <li>- Бусад холбогдох хууль</li> </ul> <p><b>Норм, нормативууд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД30-01-04/</li> <li>- Барилгын орчны тохиижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм</li> </ul>
12	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаргуугийн ус зайлцуулах шийдлийг орчны байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх.</li> <li>- Авто замын гэрэлтүүлгийг төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК руу бие даан хандаж /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах. Одоо байгаа гэрэлтүүлгийн шонг шилжүүлэх, дэд станцыг шилжүүлэх зэрэг холбогдох асуудлуудыг мөн шийдвэрлэсэн байх.</li> <li>- Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчиний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан "LED" технологиор шийдвэрлэх.</li> </ul>
13	Зураг төслийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> <li>- Инженер геодизийн ажлын тайлан.</li> <li>- Инженер геологийн судалгааны ажлын тайлан.</li> <li>- Холбогдох техникийн нөхцөлүүд.</li> <li>- Авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл. (Авто зам, борооны ус зайлцуулах, гэрэлтүүлэг, цахилгааны шугам, холбооны шугам гэх мэт)</li> <li>- Зургийн тайлбар бичиг.</li> <li>- Ажлын нэр төрөл, тоо хэмжээ.</li> <li>- Техникийн шаардлага.</li> <li>- Магадлалын ерөнхий дүгнэлт.</li> <li>- Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв.</li> </ul> <p><b>Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дэвсгэр зураг 1:500</li> <li>- Дагуу отглол хэвтээ 1:1000 босоо 1:100</li> <li>- Хөндлөн отглол 1:100</li> <li>- Уулзвар, отглолцол 1:500</li> <li>- Бүтэц 1:20</li> </ul>

14	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.</li> </ul>
15	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗНБД 22-004-2016, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04, "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04, "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНБД 32-02-12, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009, "Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам" болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх.</li> <li>- Геодези зураг зүйн тухай" хуулийн 6.1.3 дугаар заалт, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНБД 11-07-04- ын II хэсэг инженер геодезийн ажил, Теодезийн ажил "БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зурагтеслийг боловсруулах.</li> <li>- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх, зам барих үед геометр хэмжээг хангах хэмжилтийн төсөл-даалгавар боловсруулах. Геодезийн хяналтын инженерээр хянуулж баталгаажуулах.</li> <li>- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох. Хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох.</li> <li>- Гадаргуугийн ус зайлцуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлцуулах байгууламжийг цогцоор нь шийдэх.</li> <li>- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцөлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах.</li> <li>- Авто замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, нийтийн тээвэр болон автомашины зогсоол, автомашин, явган хүний гарц, дугуйн зам, ногоон байгууламж, гадаргуугийн усыг зайлцуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх.</li> <li>- Авто замын төлөвлөлтийг отглолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах.</li> <li>- Авто замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлцуулах бол тусгах.</li> <li>- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бурдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион</li> </ul>

		<p>байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх. Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолтыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах.</li> <li>- Байр зүйн болон өндрийн хэмжилтийн 11TM системд хийх.</li> <li>- Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага UCS 0902B стандартыг мөрдөх.</li> <li>- Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS 0301B стандартыг мөрдөх.</li> <li>- Улаанбаатар хотын “Нэг хот, Нэг стандарт”-ын эмхэтгэл болох UCS стандартуудыг мөрдөж ажиллах.</li> </ul>
--	--	--

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  О.МӨНГӨНШАГАЙ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН  М.БАЯРБЯМБА

Хан-Уул дүүрэг 12 дугаар хороо



Хан-Уул дүүрэг 12 дугаар хороо

